

**ДЭЛХИЙН ОРНУУДЫН ЭДИЙН ЗАСАГ, УЛС ТӨРИЙН ШИНЭТГЭЛ:
ТУРШЛАГА, СУРГАМЖ
А.Жамбал**

(ШУА–ийн Философи, социологи, эрхийн хүрээлэнгийн дэд захирал)

Монгол Улсад улс төрийн ба эдийн засгийн язгуур шинэтгэлийг зэрэгцүүлэн хийж, тодорхой ололтод хүрч, зохих туршлага хуримтлуулсаны хамт өнөө үед янз бүрийн бэрхшээл, асуудал, шинэ зорилтууд гарч ирж тулгаран тавигдаж байгаа билээ. Энэхүү үйл явцыг шинжлэн судлахад дэлхийн янз бүрийн орнуудад мөнхүү улс төрийн ба эдийн засгийн шинэтгэлийг хийж ирсэн арга зам, загваруудын талаархи асуудлыг авч үзэх нь онол, арга зүйн болон практикийн ач холбогдолтой болно.

Улс төрийн ба эдийн засгийн шинэтгэлийн харьцаа, харилцан нөлөөлөл нь улс төрийн бодлого хийгээд эдийн засаг хоёрын уялдаа, харьцаатай тодорхой хэмжээгээр холбоотой учир эхлээд эдгээрийн талаар авч үзвэл зохино. Асуудалд тийнхүү хандахдаа нэг талаас улс төрийн бодлого ба эдийн засаг хоёрын уялдаа холбоо, нөгөөтэйгүүр тэдгээрийн шинэтгэлийн харьцаа, харилцан нөлөөлөл нь хоорондоо холбоотой боловч мөн чанар, агуулгаараа тус бүртээ бие даасан өөр өөр асуудал болохыг ялгаж авч үзэх нь судалгаанд чухал болно.

Нийгмийн бодит амьдрал дээр улс төрийн бодлого ба эдийн засаг нь олон талын шижимээр уялдаж холбогдсон, нэг нь нөгөөгүйгээр орших аргагүй байдаг. Тэдгээрийг зөвхөн оюун ухааны хийсвэрлэлээр л хооронд нь ялган салгаж, тус тусд нь ойлгож болох билээ. Тэдгээрийн нэгдэл ба ялгаа, харилцан нөлөөллийг тусгаж илэрхийлсэн онолын төсөөлөл нь эдийн засгийн ба улс төрийн шинэтгэлийн харьцаа, холбоо хамаарал, тус бүрийнх нь бие даасан чанарыг танин мэдэж ойлгоход тус нэмэр болно.

Улс төрийн бодлого ба эдийн засгийн уялдаа, харьцааны асуудал нийгмийн сэтгэлгээний түүхэнд эртний үеэс тавигдаж, сэтгэгчид тэр талаар сонирхолтой бөгөөд олон янзын үзэл санаа, тайлбарыг дэвшүүлэн тавьсаар иржээ (1).

Эл асуудлыг В.И.Ленин ХХ зууны эхээр голлох шинж чанараар нь, гэхдээ эдийн засаг төвтэй сургаалын дагуу сонгодог байдлаар илэрхийлж тодорхойлсон билээ. Ленин, "... улс төрийн бодлого бол эдийн засгийн төвлөрсөн илэрхийлэл мөн...", "улс төрийн бодлого эдийн засгаас түрүүлэхгүй байж болохгүй" гэжээ (2,310). Тэрбээр эдийн засаг нь улс төрийн бодлогын үндэс суурь болж түүнийг нөхцөлдүүлж тодорхойлдог, улс төрийн бодлого нь гарал үүслээрээ хоёрдогч шинжтэй, өөрөөр хэлбэл эдийн засгийн хэрэгцээ шаардлагаар, түүнийг хэрэгжүүлэх хэрэгсэл болж үүссэн гэж үзжээ. Нөгөөтэйгүүр улс төрийн бодлого нь бие даасан чанартай, идэвхтэй, динамик шинжтэй, эдийн засгаас түрүүлдэг, эдийн засагт эргэж эерэг ба сөрөг байдлаар ихээхэн нөлөөлдөг тухай үзэл санаа бол Лениний сургаалын өөр нэг чухал тал юм. Улс төрийн бодлого нь эцсийн дүндээ нийгмийн анги бүлгүүд, тэдгээрийг төлөөлсөн улс төрийн хүчнүүдийн нийгэм, эдийн засгийн эрх ашгийн илэрхийлэл, түүнийг хамгаалах, хэрэгжүүлэх хэрэгсэл болохыг Ленин илэрүүлэн гаргажээ (3).

Ленин эдийн засаг ба улс төрийн бодлого хоёрын голлох, гүнзгий, байнгын, дахин давтагдах дотоод холбоо хамаарлыг базаж илэрхийлэн гаргасанаараа түүний энэ заалт онолын чанартай дүгнэлт болсон бөгөөд тэр нь орчин үед ч гэсэн онол-танин мэдэхүй, арга зүйн багагүй ач холбогдолтой байгааг үгүйсгэх аргагүй юм.

Орчин үед эрдэмтэн судлагчид Ленин улс төр, улс төрийн бодлогыг эдийн засгаас хэт хамааралтай, түүний хавсарга мэтээр үзсэн, түүний ахуйлаг, бие даасан чанарыг дутуу ойлгосон, Лениний энэхүү заалт, үзэл санаа хуучирч, нийгмийн

өнөөгийн амьдралд нийцэхгүй болсон гэх зэргээр шүүмжилж байна (4, 18 - 19). Үүнийг бас судалгаанд анхаарч үзэх хэрэгтэй нь ойлгомжтой.

Орчин үед эдийн засаг ба улс төрийн бодлого хоёрын алины ч шинж чанар, зорилго, хоорондын харилцан нөлөөлөл ихээхэн өөрчлөгдсөн нь бодит баримт юм. Эрдэмтэд дэлхийн янз бүрийн орны эдийн засаг, улс төрийн амьдралын туршлага, жишээ баримтын үндсэн дээр эдийн засаг ба улс төрийн бодлогын харьцаа, харилцан нөлөөлөл, түүний өөрчлөлтийн хандлагыг шинэлэг байдлаар судлаж, нэгтгэн боловсруулсан үзэл санаа, дүгнэлтүүдийг томъёолон тавьж байна. Энд тэр бүрийг авч үзэх аргагүй бөгөөд зарим голлох үзэл санааг түүвэрлэж дурьдвал:

- улс төрийн бодлого нь хүн төрөлхтөний түүхэнд аж ахуй, эдийн засгийн тогтолцоо үүсэж тогтноос ихээхэн хожуу үед үүсэн бий болсон баримтыг эдийн засаг анхдагч, улс төрийн бодлого хоёрдогч буюу түүнээс үүсмэл гэсэн утгаар тайлбарлаж ойлгох нь буруу, эдийн засаг нь улс төрийн бодлогыг төрүүлэн гаргадаг “эцэг эх” нь биш (5, 71);

- улс төрийн бодлогын бие даасан, идэвхтэй, голлох, давамгайлах чанар, үүргийг нь туйлшруулах, тэрээр эдийн засгийн бүх асуудлыг шийдвэрлэж чаддаг онцгой бүтээгч хүч мэтээр ойлгож хандах нь буруу (6,176);

- улс төрийн бодлого эдийн засагт:1) тааламжтай, эерэг байдлаар, 2) сөргөөр, 3) саармаг байдлаар, 4) зарим чиглэл, талаараа эерэг, зарим чиглэлээрээ сөрөг нөлөө үзүүлдэг (7, 71; 8,177);

- эдийн засаг ба улс төрийн бодлого хоёрын уялдаа, харилцан нөлөөлөл нь дэлхийн янз бүрийн оронд түүхэн тодорхой шинжтэй бөгөөд ялгаа онцлогтой байна гэсэн үзэл санаа, дүгнэлтүүд гарч байгаа юм.

Орчин үед эдийн засаг ба улс төрийн бодлого хоёрын харьцаанд чухал өөрчлөлтүүд гарч байна. Нийгэм хөгжин дэвших явцад түүний бүтэц, зохион байгуулалт, бүрдэл хэсэгүүд нь дотроо нарийсч, салбарлан хуваагдах үйл явц гүнзгийрч байна. Үүний дагуу улс төрийн бодлого нь дотроо эдийн засгийн, техник технологийн, цэргийн, үндэстэн угсаатны, нийгмийн, соёлын, боловсролын, гэр бүлийн бодлого гэх зэргээр мөн адил нарийсан салбарлаж тус бүртээ өвөрмөц чухал үүрэг гүйцэтгэж байна.

Төрийн эдийн засгийн бодлого нийгмийн амьдралд тэргүүлэгч үүрэгтэй болж, улс төрийн бодлогын бие даасан бүхэл бүтэн хэлбэр, өвөрмөц шинжтэй урлаг, шинжлэх ухаан болж хувирчээ. Улс орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшил төрийн эдийн засгийн бодлогоос асар их шалтгаалах болов. Газар нутгийн хэмжээ бага, байгалийн баялаг ба эдийн засгийн нөөц хомс орнууд төрийн эдийн засгийн ухаалаг бодлогын ачаар хөгжлийн өндөр түвшинд хүрч буй туршлага нь үүний нотолгоо юм. Энэ нь нийгмийн хөгжилд субъектив хүчин зүйлийн үүрэг, ач холбогдол өсөн нэмэгдэж буй ерөнхий хандлагатай нягт холбоотой.

Эдийн засгийн ба улс төрийн бодлого хоёрын уялдаа, харьцааны талаархи онолын санаалаг загвар, төсөөллийн танин мэдэхүй, арга зүйн үүрэг нь тодорхой хүрээ хязгаартай юм. Энэ хоёрын уялдаа, харьцааг эдийн засаг ба улс төрийн шинэтгэлийн харьцаа, холбоо хамааралд механикаар зөөвөрлөн буулгаж, шууд тусган ойлгож болохгүй. Учир нь эдийн засаг ба улс төрийн бодлого хоёр нь нийгмийн тодорхой орон зай, цаг хугацааны хэмжээст хоорондоо ямагт нягт нэгдэлтэй, харилцан нөлөөлөлтэй, нэг нь нөгөөгүйгээр оршин байх аргагүй байдаг. Гэтэл эдийн засгийн ба улс төрийн шинэтгэл нь дээрхи хоёр шиг ямагт салшгүй нэгдэлтэй байдаггүй, түүнчлэн ямагт зэрэгцэж хийгддэггүй, тодорхой нөхцөл байдал, шалтгаануудын улмаас цөөнгүй тохиолдолд хоорондоо зөрж, цувж, өөрөөр хэлбэл нэг нь нөгөөгөөсөө түрүүлж, эсвэл хоцорч, дангаараа хийгдэж болдогоороо онцлогтой юм.

Эдийн засгийн шинэтгэлийн гол субъект нь төр мөн. Төр эдийн засгийн шинэтгэл хийх хэрэгцээ шаардлагыг соргогоор мэдрэн ухаарч, түүнийг идэвхтэй, зорилго чиглэлтэйгээр хэрэгжүүлдэг, бас тодорхой шалтгаан, зорилгоор саатуулан барьж болдогийг туршлага харуулж байна.

Төр эдийн засгийн шинэтгэлийг санаачилж хийхдээ өөрөө өөрчлөгдөхгүй хуучнаараа байж чаддаг, түүнчлэн улс төрийн дэглэм, улс төрийн системийг ч өөрчлөхгүй, хуучнаар нь хадгалан барьж болдог ажээ. Энэ бол дан эдийн засгийн шинэтгэл хийх хувилбар юм.

Нийт нийгмийн болон эдийн засгийн шинэтгэлийн хэрэгцээ шаардлагаар, энэхүү шинэтгэлтэй давхцан улс төрийн шинэтгэл хийгдэж болдог бөгөөд энэ нь эдийн засгийн ба улс төрийн зэрэгцсэн, хос шинэтгэлийн хувилбар мөн болно.

Орчин үед дэлхийн орнуудад эдийн засгийн ба улс төрийн шинэтгэл үндсэндээ барууны орнуудын шинэчлэлийн (модернизацийн) үлгэр загвар, туршлагыг чиг баримжаа болгох замаар хийгдэж байна (9).

Эрдэмтэд нийгмийн шинэчлэлт, тэр дотор эдийн засгийн ба улс төрийн шинэчлэлтийн үндсэн хоёр янзын түүхэн загвар, туршлага байгааг тэмдэглэсэн байна. Баруун Европ, Скандинавын орнууд, Америк, Канад зэрэг орнуудын нийгэм нь XVII зууны сүүлчээр болж өнгөрсөн хөрөнгөтний түрүү үеийн хувьсгалаас хойшхи хоёр зуу гаруй жилийн туршид зөнгөөрөө, аажим, шат дарааллаар хувьсан өөрчлөгдөж, шинэчлэгдсээр эдүгээгийн шинж чанар, төлөв байдалд хүрчээ. Эдгээр оронд Дахин сэргэлт, Реформац буюу Шинэтгэлийн хөдөлгөөн, Соён гэгээрүүлэлтийн үед эхлээд нийгмийн оюун санааны хүрээ, үзэл сурталд шинэ соргог өөрчлөлт, үзэл санаа бий болж, дараа нь эдийн засаг, аж ахуйд гүн гүнзгий өөрчлөлт, шинэчлэлт явагдаж чухал ололт, үр дүнд хүрчээ. Дараачийн үед тэдгээрийн тусгал, нөлөөгөөр улс төрийн дэглэм, төрийн засаглал шинэчлэгдэж ардчилал, хүний эрх, эрх чөлөө хангагдах болсон байна.

Эрдэмтэд барууны орнуудын нийгмийн энэхүү шинэчлэлтийг “анхдагч”, “өөрийн зөнгөөрөө”, дотоод хэрэгцээ шалтгаанаараа хэрэгжсэн шинэчлэлт гэж нэрлэжээ. Эдгээр орнуудын хоёр зуу гаруй жилийг дамжин байж хүрсэн хөгжлийн одоогийн түвшин, шинэчлэлтийн үр дүн, загвар нь XX зууны үеийн шинэчлэгдээгүй, уламжлалт, хоцрогдолтой байсан нийгэм, улс орнуудад жишээ, загвар болсон талтай юм. Энэхүү загвар, үлгэр жишээг XX зуунд тусган авч нийгмийн шинэтгэл, шинэчлэлтийг харьцангуй богино хугацаанд зорилго чиглэлтэйгээр дээрээс санаачилж хийсэн олон арван орон бий билээ. Судлагчид тийм шинэчлэлтийг “хоёр дахь” буюу “тусгалын шинэчлэлт” гэж нэрлэсэн байна (10, 458).

XX зуунд дэлхийн арав гаруй оронд пролетари, тариачдын гэгдэх хувьсгал ялж, социализмын замаар замнасан нь нийгмийн өвөрмөц маягийн шинэчлэлт байлаа. Гэвч эл шинэчлэлт олон янзын шалтгаанаар нийгмийг цаашдын ирээдүйгүй болгож мухардал, хямралд хүргэсэн байна. Түүний өр төлөөс болж социализмаас аргагүйн эрхэнд татгалзах, зах зээлийн эдийн засаг, улс төрийн ардчилал, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай, жинхэнэ ёсоор нь хангах зорилго бүхий шинэчлэлтийн барууны загвар, замыг цаг хугацаа алдаж дахин сонгох шаардлага гарсныг социалист байсан орнуудын туршлага харуулсан билээ. Монголын нийгэм одоо шинэчлэлтийн энэхүү загвар, замаар явж байна.

XX зуунд дэлхийн хэдэн арван улс орон нийгмээ барууны загвараар шинэчлэхдээ өөрийн орны өвөрмөц онцлог, тухайн үеийн түүхэн тодорхой нөхцөл байдал, хүчин зүйлсийг харгалзан үзэж хоорондоо ялгаатай хэд хэдэн замнал, туршлага, загвараар хэрэгжүүлсэн байна. Энд наандаж дараах үндсэн гурван загвар, туршлага байгааг дурдах хэрэгтэй. Нэгдүгээрт, БНСУ, Тайвань, Филлиппин зэрэг Азийн орнууд XX зууны хоёрдугаар хагаст нийгмийн хуучин байгуулал, улс төрийн

авторитар дэглэмийг өөрчлөхгүйгээр, авторитар төрийн хүч нөлөөгөөр дан эдийн засгийн шинэтгэл хийж улс төрийн ба нийгэм, оюун санааны язгуур өөрчлөлт, шинэтгэлийг зориуд хойшлуулан тавьжээ. Эдгээр оронд эдийн засгийн шинэтгэл зохих үр дүнд хүрч тэр нь нийгмийн амьдрал, бүтэцэд эргэн нөлөөлж хүн амын амьдрал, боловсрол, соёлын түвшин дээшилсэн байна. Энэ нь хүн амын улс төрийн идэвх, соёл сэргэн дээшлэх, нийгэм, эдийн засгийн эрх ашгаа ухамсарлаж хамгаалсан дунд анги улс төрийн бодит хүч болж гарч ирэхэд нөлөөлжээ. Эрх баригчид энэ байдлыг бодитойгоор тооцон үзэж нэгэнт бий болсон эдийн засаг, нийгэм, соёлын шимтэй бэлэн хөрс сууринд үндэслүүлж улс төрийн шинэтгэлийг огцом биш, шат дараалуулж тодорхой бодлого, зохицуулалттайгаар хийсэн байна (11).

Хоёрдугаарт, дэлхийн хэд хэдэн оронд төрийн эргэлт, улс төрийн хувьсгал гарсны улмаас улс төрийн шинэ дэглэм, шинэ төр бүрэлдэн бий болж дараагийн шатад тэдгээрийн идэвхтэй үйл ажиллагаа, хүчээр эдийн засгийн шинэтгэл хийсэн туршлага байгаа юм.

Гуравдугаарт, эдийн засгийн ба улс төрийн шинэтгэлийг нэгэн зэрэг эхэлж хослуулан хийж буй туршлага байна.

Урьд нь социализмын замаар замнаагүй, өмчийг нийгэмчлээгүй, эдийн засагт нь зах зээлийн элемент, зохицуулалт тодорхой хэмжээгээр хадгалагдаж байсан орнууд дахь эдийн засгийн шинэтгэлээс социалист байсан орнууд дахь шинэтгэл ихээхэн ялгаатай, эрс, радикал шинжтэй байгаа өөр нэг өвөрмөц онцлогтой, шинэ туршлагыг дурьдах хэрэгтэй. Социалист байсан орнууд ба одоо социалист хэвээр байгаа зарим оронд (Хятад, Вьетнам) улсын (төрийн) өмчинд үндэслэсэн төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг шинэтгэж төрийн зохицуулалттай зах зээлийн, олон хэвшилтэй эдийн засагт шилжүүлэх зорилт нь үндсэндээ хоёр янзын хувилбар, хэлбэрээр хэрэгжиж байгааг хятадын эрдэмтэн Сао Жүн Кай дурьдаж тэмдэглэсэн байна (12, 421). Тэр нь нэгдүгээрт, хуучны социалист байсан орнуудад хувьсгал гарсны улмаас улс төрийн систем, дэглэм нь огцом эргэж өөрчлөгдснийг дагалдаж эдийн засаг нь өөрчлөгдөж шинэчлэгдэх болсон, хоёрдугаарт, нийгмийн социалист байгуулал, улс төрийн дэглэм, албан ёсны үзэл суртал нь зарчмын хувьд онцын өөрчлөгдөөгүй хэвээр байгаа нөхцөлд засгийн газар нь дээрээс санаачилж социалист эдийн засгийг төлөвлөгөөтэйгээр, төрийн зохицуулалт, хяналттайгаар шинэтгэж зах зээлийн харилцаанд шилжүүлж чухал амжилтанд хүрч байгаа туршлага юм.

Сао Жүн Кай Монгол Улс дахь улс төрийн ба эдийн засгийн шинэтгэл эхний хувилбараар, Хятад ба Вьетнам дахь эдийн засгийн шинэтгэл хоёр дахь хувилбараар хэрэгжиж байна гэжээ.(13, 421).

Хуучин социалист байсан орнуудад эдийн засгийн шинэтгэл хийх явцад эдийн засгийн техник, технологийн хоцрогдолыг даван туулах, бүтэцийн өөрчлөлт хийх, хүнд аж үйлдвэрийн гол салбаруудыг урьдын цэрэг дайны зориулалтаас нийгмийн зориулалтад шилжүүлж өөрчлөх зэрэг нийтлэг зорилтоос гадна төрийн монопол өмчийг задлаж хувьчлах, зах зээлийн харилцаанд шилжүүлэх, банк, санхүү, зээлийн системийг өөрчлөх, эдийн засгийг бүхэлд нь нээлттэй болгож чөлөөлөх зэрэг өвөрмөц, шинэ, нарийн ээдрээтэй зорилтууд зайлшгүй гарч ирсэн билээ.

Дэлхийн янз бүрийн орнууд дахь эдийн засгийн ба улс төрийн шинэтгэлийн явцад эрдэмтэн судлагчдын анхаарлыг өөртөө татаж, хоорондоо зөрөө ялгаатай хариу тайлбар, үзэл бодол, дүгнэлтүүдийг үүсгэж буй ээдрээтэй асуудлын нэг бол эдийн засгийн ба улс төрийн шинэтгэлийн харьцаа, тэдгээрийг цаг хугацааны хувьд зэрэгцүүлж хийх, эсвэл шат дараалуулж, нэгнийх нь үр дүнд нөгөөг нь түшиглүүлж

цувуулж хийх, эдгээр хувилбаруудын аль алины эерэг, давуу тал ба сөрөг үр дагавар, гарах саад бэрхшээлийн тухай асуудал мөн болно.

Энэ талаар судлагчдын багагүй хэсэг нь дэлхийн янз бүрийн орон дахь нийгмийн өөрчлөлт, шинэтгэлийн үр дүн, туршлагыг судлах үндсэн дээр эдийн засгийн шинэтгэлийн үр дүн, ололт амжилт нь улс төрийн ардчилсан шинэтгэлээс шууд шалтгаална, өөрөөр хэлбэл тэдгээрийн хооронд нягт холбоо хамаарал бий гэж 1950-иад оноос 1970-аад он хүртлэх үед үзэж байв. Энэхүү үзлийг тууштай баримтлагчдын нэг болох С. М. Липсет эдийн засгийн шинэтгэл ба түүний ололт, үр дүн нь улс төрийн ардчилсан шинэтгэлийн зайлшгүй шаардлагатай үндэс суурь, нөхцөл нь болдог, аль нэг оронд ардчилал бэхжиж эргэлт буцалтгүй, бат бэх амьдрах чадвартай болохын тулд тэр орны эдийн засаг хэдэн арван жилийн туршид тууштай хөгжсөн байх шаардлагатай, нөгөө талаас улс төрийн бат бэх ардчилал нь эдийн засгийн цаашдын тогтвортой хөгжил, ололт амжилтын баталгаа болдог гэж 1960-аад оны эхэн үед үзэж байв (14, 213-214).

Үнэндээ 1970-аад оны үед дэлхийн өндөр хөгжилтэй 19 орноос Испани улс л ганцаараа улс төрийн авторитар дэглэмтэй, бусад нь эдийн засаг, аж үйлдвэрийн өндөр хөгжил ба улс төрийн ардчилсан дэглэм хоорондоо харилцан нийцэж тохирсон орнууд байлаа. Энэхүү баримт, туршлага барууны өндөр хөгжилтэй орнудад одоо ч гэсэн бодитой хэвээр байна. Үүнийг иш үндэс болгож эрдэмтэн судлагчдын багагүй хэсэг нь нийгмийн цогцолбор шинэтгэл хийж буй орнуудад эдийн засгийн ба улс төрийн шинэтгэл цаг хугацааны хувьд хоорондоо нягт холбоотойгоор, зэрэгцэж хийгдэх нь хамгийн зөв зүйтэй, үр дүнд хүрэх хувилбар мөн гэсэн ерөнхий дүгнэлтэд хүрчээ. Түүнийг З. Бжезински, Ч. Эндрейн, Б. Геддес зэрэг томоохон эрдэмтэд одоо ч баримталж байгаа юм.

Гэвч эл дүгнэлт дэлхийн улс орон бүрт нийцэж тохирох түгээмэл шинжтэй биш, эдийн засаг ба улс төрийн шинэтгэлийн харьцаа, уялдаа нь өрнө ба дорно, тэдгээрийн янз бүрийн бүс нутаг, үндэстэн, ард түмнүүдийн соёл, иргэншлийн өвөрмөц онцлог зэрэг олон янзын нөхцөл, хүчин зүйлээс шалтгаалж харилцан ялгаатай, олон янзын хэлбэр, арга, хувилбартай байж болох нь дараагийн үеийн туршлагаар нотлогдсон билээ.

1960-1970-аад оны үед Латин Америк, Зүүн хойд ба өмнөд Азийн хэд хэдэн орон улс төрийн ардчилсан шинэтгэл хийхгүйгээр, оршин буй авторитар дэглэмийн хүчээр эдийн засгийн шинэтгэл хийж чухал ололт, үр дүнд хүрчээ. Арабын ертөнцийн ихэнх орнууд хаант засагтай хэрнээ нефтийн экспортод голлон тулгуурлаж эдийн засгийн хөгжлөөр дээгүүр түвшинд байсаар байна. Хятад ба Вьетнам улс нийгмийн социалист байгуулалтай, улс төрийн авторитар дэглэмтэй хэрнээ дан эдийн засгийн шинэтгэл хийж өндөр ололт, үр дүнд хүрч байгаа нь өөр нэг бодит туршлага, баримт юм.

Энэ бүхэн эдийн засгийн ба улс төрийн шинэтгэлийн хооронд салшгүй холбоо хамаарал бий бөгөөд тиймээс тэдгээрийг заавал зэрэгцүүлж хийх шаардлагатай гэсэн онолын дүгнэлт, түүнд тулгуурласан практикийн саналыг эргэн харж засварлах, амьдралын өөр, шинэ баримт, туршлагыг судлаж онол, танин мэдэхүйн эрэл хайгуул хийхэд түлхэц өгч байгаа юм. Үүний дагуу эрдэмтэдийн зарим хэсэг нь ардчилал, хүний эрх, эрх чөлөөг хангах, улс төрийн шинэтгэл хийх явдал хэдийгээр чухал бөгөөд асар их үнэт чанартай боловч нийгмийн хэвийн оршин тогтнолд ч, хүмүүсийн амьдралд ч эдийн засгийн хөгжил, шинэтгэл юугаар ч сольшгүй, зайлашгүй шаардлагатай болно, эдийн засгийн шинэтгэл хийж үр дүн, амжилтад хүргэх зорилтыг ардчилсан дэглэмийг бодвол авторитар дэглэм илүү хангана гэсэн үзэл санааг дэвшүүлэн тавьж тодорхой жишээ, бодит баримтуудаар нотлох болсон байна. Энэ үзлийг баримталдаг эрдэмтэд дэлхийн цөөнгүй орны туршлага, үлгэр жишээг иш

үндэс болгож нийгмийн шинэтгэл, ялангуяа эдийн засгийн шинэтгэлийг дээрээс, авторитар дэглэмийн хүч нөлөөгөөр хийх нь эдийн засаг, санхүү, материаллаг ба хүн хүчний нөөц боломж, улс төрийн үйл ажиллагааг төвлөрүүлж нийт нийгэм, ард түмний эрх ашигт нийцсэн зайлшгүй чухал, тулгамдсан гол зорилтыг түүхэн богино хугацаанд хэрэгжүүлэх бололцоо олгодогийг илрүүлэн гаргасан байна(15, 194).

Эрдэмтэд хэд хэдэн орны туршлагыг судалсны үндсэн дээр нийгэм, эдийн засгийн шинэтгэлийг дээрээс төрийн бодлого, үйл ажиллагаагаар хэрэгжүүлэхдээ тухайн үндэстэн, олон түмний урам зоригийг бадрааж чадах, нийт нийгмийн хүч энергийг нэгдмэл нэг зорилгод чиглүүлэн дайчилж чадах үндэсний үзэл санаа, лоозон, төрийн үзэл суртал, түүнчлэн нийтээр хүлээн зөвшөөрсөн үндэсний удирдагч, түүний зэрэгцээ эдийн засгийн ба улс төрийн манлайлагч хоёр гол удирдагч бас нэгэн зэрэг хэрэгтэй гэсэн үзэл санааг гарган тавьж байгаа юм (16).

Эрдэмтэдийн дээрхи үзэл санаа эдийн засгийн шинэтгэл хийж ололт амжилтад хүрэхийн тулд улс төрийн шинэтгэлийг түүнтэй заавал зэрэгцүүлж хийх зайлшгүй шаардлагатай биш, түүнийг эдийн засаг тогтворжиж, хөгжлийн зохих түвшинд хүртэлх хугацаагаар хойшлуулж, саатуулан барьж болно гэсэн давхар утга санаа, практикийн саналыг агуулж байгаа юм.

Эдийн засгийн ба улс төрийн шинэтгэлийг орон зай, цаг хугацааны хувьд зэрэгцүүлж хийх нь ололт амжилт ба дутагдал доголдол, эерэг чухал ба сөрөг муу үр дагаварын алиныг ч дагуулдагийг тэрхүү зэрэгцсэн хос шинэтгэлийг хэрэгжүүлж байгаа орнууд, тэр дотор манай орны өнөөгийн туршлага харуулж байна. Зэрэгцсэн хос шинэтгэл хийх нь нийгмийн хүч энергийг энэхүү хоёр том зорилтыг хэрэгжүүлэхэд нэгэн зэрэг чиглүүлж зарцуулах, тэгснээрээ нийгмийн түүхэн цаг хугацааг хэмнэж хожих, нийгмийн амьдрал цогцолбор, бүхэл байдлаар шинэчлэгдэх, эдийн засаг ба улс төрийн системийн ардчилсан хөгжил бие биеэ дэмжиж зэрэг хангагдах боломж олгодог зэрэгээрээ чухал ач холбогдолтой, давуу сайн талтай юм.

Гэвч эдийн засгийн ба улс төрийн шинэтгэлийг зэрэгцүүлж хийх нь ололт, дурдсан давуу талаасаа дутуугүй хэмжээний саад бэрхшээл, сөрөг муу үр дагавар, нарийн ээдрээтэй асуудал, гажуудлыг төрүүлэн гаргадагийг мөн манай орны болон хуучин социалист байсан хэд хэдэн орны өнөөгийн амьдрал, туршлага харуулж байна. Тийм бэрхшээл, хурц асуудал, алдаа гажуудлын тоонд улс төрийн шинэтгэл ихэнхдээ хэлбэрийн талаасаа эдийн засгийн шинэтгэлийн бодит үйл явц, үр дүнгээс түрүүлж тэдгээрийн хооронд зай завсар, зөрчил үүсэхэд хүргэдэг, өөрөө шинэ тутам өөрчлөгдөн шинэчлэгдэж буй, хараахан бүрэн гүйцэд төлөвшин бэхжиж амжаагүй байгаа улс төрийн ардчилсан шинэ систем, ардчилсан төр нь эдийн засгийн шинэтгэлийн нарийн төвөгтэй, бэрхшээлтэй зорилтуудыг төдийлөн амжилттай хэрэгжүүлж чадахгүйд хүрэх, түүнчлэн улс төрийн нам, бизнес, ашиг сонирхолын бүлэгүүд ардчиллаар бамбай барьж эдийн засагт бохир нөлөө оролцоо, хяналтаа тогтоох, эдийн засгийн тодорхой зорилт, асуудлуудыг зохиомолоор улс төржүүлж хэрэгжилтэд нь саад бэрхшээл учруулах, эцэстээ улс төр, бизнес хоёр хоорондоо бохир байдлаар хутгалдах, авилга, эдийн засгийн гэмт хэрэг, улс нийгмийн өмч хөрөнгө, нөөцийг элдэв гэмт аргаар луйвардан завших, эдгээрийн нөлөөгөөр ардчилал, эрх, эрх чөлөө, парламентын сонгууль, өмч хувьчлал, эдийн засгийн либералчилалын нэр хүнд, үнэ цэнэ унах, нийгмийн хяналт, сахилга, дэг журам алдагдах зэрэг сөрөг үзэгдэл, гажуудал орж байгаа юм.

Тиймээс ч эдийн засгийн ба улс төрийн зэрэгцсэн шинэтгэлийн харьцаа, түүний давуу хийгээд сул тал, ололт дутагдалын асуудал эрдэмтдийн анхаарлын төвд байсаар байгаа юм. Манай эрдэмтэдээс академич Т.Намжим дэлхийн зарим оронд болон монголын нийгэмд эдийн засаг, улс төрийн шинэтгэл хийсэн туршлага, ер нь эдийн засгийн ба улс төрийн хөгжлийн харьцааны асуудлыг авч үзээд эдийн

засгийн хөгжил урьтаж, улс төрийн шинэтгэл, ардчилал түүнийг дагадаг нь зүй тогтолт чанартай юм гэсэн дүгнэлт хийсэн байна (17). Бид мөн ийм саналыг дэмждэг.

Дээр авч үзсэн зүйлийг товч дүгнэж өгүүлбэл нэг талаар хүний нийгэм бүхэлдээ, тэр дотор түүний эдийн засаг, улс төрийн хүрээ нь өөрчлөгдөж шинэчлэгдэх нь жам ёсны, түгээмэл чанартай түүхэн хандлага бүхий үйл явц юм. Нөгөө талаар тэдгээр шинэтгэл, шинэчлэлт нь хатуу тогтсон, нийтээр заавал дагаж мөрдөх ганц нэгхэн загвартай биш ажээ. Тэр тусмаа нийгмийн өөрчлөлт, шинэтгэлийн барууны загвар, туршлага нь дэлхийн орон бүхэнд таарч тохирох бэлэн жор, шалгарсан ганц зам мөр биш бөгөөд дэлхийн орнууд эдийн засаг ба улс төрийн шинэтгэл хийх өөртөө тохирсон, хоорондоо нийтлэгтэйн зэрэгцээ үндэсний ялгаа онцлогтой өөр өөрийн зам мөр, хэв загвартай ажээ

Ишлэл, тайлбар

1. Эдийн засаг ба улс төрийн бодлогын холбоо хамаарлын талаархи нийгэм-улс төр, эдийн засгийн сэтгэлгээний голлох үзэл санааны тоймыг дараах бүтээлүүдээс дэлгэрэнгүй үзнэ үү. Үүнд:
 - История политических и правовых учений. Учебник для вузов. Под общ. ред. В.С.Нерсисянца. М., 1997
 - История экономических учений. Учебное пособие. Под ред. В.Автономова и др. М., 2001
2. Ленин В.И. Үйлдвэрчний эвлэлийн тухай, цаг үеийн байдлын тухай, нөхөр Троцкий, Бухарин нарын алдааны тухай дахин өгүүлэх нь. – В.И.Ленин. 12 боть түүвэр зохиол. 11 дүгээр боть. 1920 – 1921. Монгол хэлээр. М., 1987
3. Эдийн засаг ба улс төрийн бодлогын харилцан нөлөөллийн талаархи В.И.Лениний үзэл баримтлалыг дараах бүтээлээс дэлгэрэнгүй үзнэ үү. Үүнд:
 - Азаров Н.И. В.И.Ленин о политике как общественном явлении. 2 – ое изд. М., 1975
4. Панарин А.С. Философия политики. Учебное пособие. М., 1996
5. Соловьев А.И. Политология: Политическая теория, политические технологии. Учебник для вузов. М., 2001
6. Крапивенский С.Э. Социальная философия. Учебник для вузов. 3 – ое изд. Волгоград, 1996
7. Соловьев А.И. Дурдсан зохиол
8. Крапивенский С.Э. Дурдсан зохиол
9. Манай оронд нийтлэгдэж буй нийгмийн ухааны зохиол, бүтээлүүдэд шинэтгэл, шинэчлэлт гэсэн ойлголт, нэр томъёог хооронд нь адилтгах, хутган ойлгож хэрэглэх тохиолдол цөөнгүй гарч байна. Бид реформыг шинэтгэл, модернизацийг шинэчлэлт гэсэн нэр томъёогоор тэмдэглэн ойлгож байгаа эрдэмтэдийг дагаж байгаа болно.
10. Политология. Учебник для вузов. Под ред. М.А. Василика. М., 1999
11. Энэ талаар дараах бүтээлүүдээс тодорхой үзнэ үү. Үүнд:
 - Всемирная история. Под ред Г.Б.Поляка, А.Н. Марковой. – М., 2000, 570 – 582 дахь тал.
 - Чарльз Ф Эндрейн. Сравнительный анализ политических систем (Эффективность осуществления политического курса и социальные преобразования) Перевод с англ. – М., 2000
 - Буров В.Г. Модернизация тайваньского общества. М., 1998
12. Ширэм Сао Жүн Кай. Монгол Улсын эдийн засгийн шилжилтийн үед тулгарсан асуудлууд. – Олон улсын монголч эрдэмтэдийн VII их хурал (1997.812 – 13. УБ) I боть. УБ., 1999
13. Мөн тэнд.
14. Гаджиев К.С. Введение в политическую науку. Учебник для вузов. 2–оо изд. М., 1997
15. Буров В.Г. Дурдсан зохиол
16. Жамбал А. Улс төрийн авторитар дэглэмийн зарим асуудал. – Зүүн хойд Ази судлал (сэтгүүл). 1995, 1 1 – 2 (5 - 6), 34 – 45 дахь талд
17. Намжим Т. Хөгжил урьтаж, ардчилал дагадаг зүй тогтол. – “Зууны мэдээ” сонин. – 2007.01.03. 11 (2449)